

Эрдэнэзул: Бэрхшээлийг даван туулж бие даасан амьдрал, манлайлал руу...



Зулаа 4 жилийн өмнө автомашины осолд орж, хүзүү нь хугарчээ. Үүнээс болж суганаас доош биеийн хэсэг нь мэдээгүй болсон байна. Тухайн үед тэрээр их сургуулийн 1-р курсын оюутан байсан бөгөөд “суралцах” хүсэлдээ автан ажлаасаа гарч, их сургуульд элсэж ороод удаагүй байжээ. Улмаар сургуулиасаа 1 жилийн чөлөө авч, 3-р курсээсээ буцаж орсон байна. Ангийнхантайгаа хамт сургуулиа төгсөхийн тулд 2-р курсийнхээ хичээлийг ч гэсэн нөхөж үзэх шаардлагатай байсан тул 2,3-р курстээ давхар суралцжээ. Ингээд өдөржин завгүй хичээл хийдэг байсны ачаар ангийнхантайгаа хамтдаа

сургуулиа төгсөж, сэтгүүлчийн мэргэжил эзэмшжээ. Түүний хувьд сургууль дотроо нааш цааш явахад нэлээд хүндрэлтэй байсан байна. Ангийнх нь хүүхдүүд 3 давхрын анги хүртлээ үүрэх, тэргэнцэрийг нь зөөх зэргээр тусалдаг байжээ. Хичээлдээ ч дуртай, оюутан ахуй цаг нь дурсамжтай сайхан өнгөрч байж. Нэг өдөр таксигаар сургууль руу гаа явж байтал жолооч нь “Ер нь чам шиг хүмүүс нэгэнт ажилд орж чадахгүйгээс хойш их сургуульд сурах шаардлага байгаа юм уу. Гэр бүлийнхэндээ төвөг учруулаад, өөрөө ч ингэж зовон байж гадуур гарах ямар хэрэгтэй юм.” гэж хэлжээ. Таксины жолоочийн хэлсэн энэхүү үг түүнд хүндээр тусч, 3 хоног гэрээсээ ч гараагүй байна. Сургуулиасаа ч гаръя, гадуур гарахаа ч больё гэж боджээ. Гэвч аажимдаа “би ингэж их хүчин чармайлт гаргаж байхад яагаад эргэн тойрны хөндлөнгийн хүмүүс миний өмнөөс шийдвэр гаргах ёстой юм бэ” хэмээн бодох болж, харин ч ингэх тусам би нийгэмд илүү идэвхтэй оролцох ёстой юм байна гэж бодож эхэлжээ. Түүний ард ээж, хайрт охин Хүслэн хоёр нь үргэлж бат найдвартай зогсож байдаг. Ялангуяа осолд орох үед нь зургаахан настай байсан балчир охин нь түүнд өдөр тутмын бүхий л зүйл дээр нь тусалдаг байсан аж. Одоо 11 настай Хүслэн охин маш ухаалаг, хэрсүү болжээ. Хамаатных нь хүүхдүүд гэрт нь ирэхэд тэднийг удирдан, бүх зохион байгуулалтыг хийдэг байна. Зулаа их сургуулиа төгсөөд Түгээмэл хөгжил бие даан амьдрах төвд ажиллаж байна. Цаашид тус төвийн тэргүүн Ундрахбаяр шиг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах чиглэлээр ажиллах, эмэгтэй манлайлагч болох зорилготой байна хэмээн өгүүлж байлаа.

Болдбаатар: Спортоор дамжуулж нийгэмд оролцох замаа нээж чадсан.

Болдбаатар Увс аймагт төрж өссөн бөгөөд ахлах ангид байхдаа нүд нь муудаж, харааны бэрхшээлтэй болжээ. Тухайн үед Улаанбаатарт ирж эмчилгээ хийлгэсэн боловч амжилттай болоогүй учраас нэлээд удаан хугацааг гэртээ өнгөрүүлсэн байна. Нэг удаа телевизээр харааны бэрхшээлтэй хүмүүс жүдо бөхөөр хичээллэж байгаа тухай



гарсан нь түүний хувьд шинэ соргог мэдээлэл болж чаджээ. Ингээд гэрийнхнээрээ Паралимпийн хорооны утсыг хайлгуулж олоод холбогдтол Харааны бэрхшээлтэй хүмүүсийн уулзалт чуулган болох тухай мэдээллийг өгчээ. Ингээс тус хуралд оролцохоор Улаанбаатар хотыг зорьсон байна. Хурлын үеэр Хараагүйчүүдийн үндэсний холбооны төлөөлөлтэй

уулзалдаж, Дани улсын дэмжлэгтэйгээр зохион байгуулагдсан Манлайлагч бэлтгэх сургалтанд хамрагджээ. Сургалтын дараа Увс аймагтаа буцаж очоод Хараагүйчүүдийн үндэсний холбооны салбар зөвлөлийг байгуулсан байна. Салбар зөвлөлийн даргаар ажиллах хугацаандаа харааны бэрхшээлтэй хүмүүст зориулж олон төрлийн үйл ажиллагааг зохион байгуулсан ба нэн ялангуяа спортыг хөгжүүлж дэлгэрүүлэхэд ач холбогдол өгч ажиллажээ. Өөрөө ч гэсэн жүдо бөхөөр хичээллэн, улсын аваргын тэмцээнд хэд хэдэн удаа медальт байранд шалгарчээ. Тэрээр “Спортоор хичээллэх нь” нийгмийн оролцооны томоохон хөдөлгөгч хүч хэмээн ярьж байлаа. Болдбаатар өдгөө Хараагүйчүүдийн үндэсний холбооны Ерөнхий нарийн бичгийн албыг хашихын сацуу Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)-ын сургагч багшаар ажиллаж байна. Харааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан хөтөч зам дундаасаа байхгүй болох, эсвэл хөтөч зам дээр гэрлийн багана, хогийн сав зэргийг суурилуулсан байх гэх мэтээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд ганцаараа бие дааж явах орчин хангалттай бүрдээгүй. Тийм учраас бодлого, төсвийг хариуцдаг төрийн байгууллагын шийдвэр гаргах түвшний хүмүүст зориулж DET сургалтыг хийх хүсэлтэй байна хэмээн өгүүлж байлаа. Тус холбооны харьяа Харааны бэрхшээлтэй хүмүүс ажилладаг кофе шопд нэгэн яамны сайд асан хүн ирээд “Нэгэнт ажил хийж чадахгүйгээс хойш гэртээ халамжийн мөнгөө аваад амьдарсан нь дээр” гэж хэлсэн байна. Баристагийн сургалтанд суралцаж төгсөөд урам зоригтойгоор ажиллаж буй тэдэнд энэ үг цочир тусжээ. Болдбаатар энэ ярианаас ухамсар, ойлголтын саад бэрхшээлийг улам илүү мэдэрчээ. Тийм учраас цаашид эдгээр саадыг арилгаж, орчныг сайжруулахын төлөө ажиллана гэж байлаа.



Болороо:Боловсрол бол нийгмийн оролцооны хаалгыг нээх түлхүүр

Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)-ын сургагч багш нар дотроос DET сургалтыг хамгийн их хийсэн нь Болороо. Тэрээр ХНХЯ-д мэргэжилтнээр ажиллахын сацуу ахлах сургагч багшийн хувиар өнөөг хүртэл нийтдээ 89 удаа, 3976 гаруй хүмүүст сургалт хийгээд байна.Түүний хувьд төрөх үеийн хүндрэлийн улмаас тархины саажилттай болсон бөгөөд 5 нас хүртлээ суух чадваргүй, хэвтрийн байдалтай байжээ. Гэсэн хэдий ч сургуульд сурах чин хүсэлтэй байсан тул гэртээ дасгал хөдөлгөөн хийж эхлэн, үзэг барьж сурахын тулд уйгагүйгээр сургуулилт хийсэн байна. Үүний үр дүнд хэдийгээр хөл, гарын хөдөлгөөн нь хангалттай хэмжээнд сайжраагүй ч 9 настайдаа энгийн сургуульд элсэж оржээ. Гэвч эргэн тойрных нь хүүхдүүд айж эмээх, эсвэл гадуурхах явдал гарч байсан байна. Иймээс ээж нь сургуулийн захиралтай уулзаж ярилцан, багш нар нь анги бүрээр орж Болороог бусад хүүхдүүдээс ялгарах зүйл байхгүй, хамтдаа энэ сургуульд суралцах найз чинь юм шүү гэж тайлбарлаж өгчээ. Ингээд ерөнхий боловсролын сургуулиа амжилттай төгсч, их сургуульд орох үед ээж нь “Миний охин санхүүгийн чиглэлээр суралцаад аль нэг байгууллагат нягтлан бодогч ч юм уу олон хүнтэй харьцдаггүй ажил хийвэл зүгээр биш үү” гэж хэлсэн байна. Үүнийг сонсоод яагаад би заавал бусдаас нуугдах ёстой гэж? Харин ч ил гарч, нийгмийг өөрчлөх ёстой гэж бодох болжээ. Тиймээс ч МУИС-ын Улс төр судлалын ангид элсэн орсон юм. Оюутан байхдаа сонин хэвлэл их уншдаг байсан бөгөөд тухайн үед хөгжлийн бэрхшээлтэй хамааралтай нийтлэлүүдэд ихэнхдээ

“тэргэнцэр хандивлав” гэх мэт мэдээлэл л гардаг байжээ. Мэдээж үр өгөөжтэй ажил боловч миний туулж ирсэн хөгжлийн бэрхшээлийн асуудлуудыг шийдвэрлэхэд хангалттай байж чадах уу? хэмээн эргэлзэх болжээ. Болороо 2 жилийн өмнө DET сургагч багш бэлтгэх сургалтанд хамрагдан “энэ нийгэмд олон янзын хүмүүс бий, хүн нэг бүрийг хүлээж авахгүй байгаа нийгэм өөрөө хөгжлийн бэрхшээлийн асуудлыг бий болгож байгаа юм байна” гэдгийг ойлгожээ. Ингээд надад тулгардаг асуудлуудыг шийдвэрлэхэд DET хамгийн тохирох арга юм байна, би энэ сургалтыг олон хүмүүст хүргэх ёстой гэж шийджээ. Өнөөг хүртэлх түүний замналыг эргэн харвал нийгмийн оролцоонд нэн чухал үүрэг гүйцэтгэсэн хэд хэдэн зүйлүүд тохиолдож байжээ. Тэдгээрийн нэг нь бага ангийн багш нь Болороод өндөрдөөд байсан ширээг нам ширээгээр сольж өгсөн явдал байлаа. Боловсрол бол нийгэмд оролцох хамгийн эхний алхам. Ялангуяа суурь боловсролтой болсноор хувь хүний өөрийнх нь хүчин чармайлтаас шалтгаалах хэдий ч дээд боловсрол эзэмших боломж бүрдэнэ. Сургууль нь түүнд тохирсон орчныг бүрдүүлж өгсөн явдал болон энгийн сургуульд хөгжлийн бэрхшээлгүй хүүхдүүдтэй хамтдаа суралцсан нь одоогийн Болороог бий болоход чухал нөлөө үзүүлжээ. “Би өмнө нь зөвхөн тархины саажилттай хүмүүсийг төлөөлж дуу хоолойгоо хүргэхийг хүсдэг байсан бол одоо өөрчлөгдсөн. Ялгаварлан гадуурхах, тусгаарлах, оролцоог хязгаарлах гэх мэт асуудлууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийтлэг тулгамддаг. Тийм учраас бүх хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төлөөлөн дуу хоолойгоо хүргэхийг зорилго болгон хичээн ажиллах болно” хэмээн тэрээр ярьж байлаа.

Уянгасайхан: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хөгжих боломжийг нь олгох хэрэгтэй

Уянгасайхан нь 2016 оны 12-р сард зохион байгуулагдсан Сургагч багш бэлтгэх сургалтанд хамрагдсан анхны төгсөгчдийн нэг. Түүнээс хойш DET сургалтаар дамжуулж нийгэмд нөлөөлөх ажлыг идэвхтэй явуулж байна. Тэрээр хэл ярианы бэрхшээлтэй бөгөөд өөрийн санал бодлыг бусдад чөлөөтэй илэрхийлэхэд хүндрэлтэй, сандарсан үедээ ярьж чадахгүй байх тохиолдол ч бий. Мөн саажилттай учраас алхах үедээ бага зэрэг тэнцвэргүй явдаг байна. Тийм учраас гудамжаар зөрж өнгөрөх хүмүүс байнга гайхсан, сонжсон байдлаар хардаг. Хүмүүсийн харах өнцөг, ойлголтыг яавал өөрчлөх боломжтой вэ? Түүнийг сургагч багш болж, хүмүүсийн өмнө яриа хийж, өсөн дэвшиж буйг хараад гэрийнхэн нь маш их баярладаг. Одоо ч гэсэн ярих үедээ сандардаг боловч цаашид сургалтын дасгал ажлуудыг нэг нэгээр нь давтаж, өөрийн болгохыг зорьж байна. Тэрээр сурагч байхдаа жирийн сургуульд сурч байсан. Бичих үед хугацаа шаардлагатай учраас ангийнхаа хүүхдүүдийн дэвтрийг гэр лүү гээ авч яваад хичээлээ хийдэг байжээ. Ахлах сургуульд дэвшин суралцах хүсэлтэй байсан боловч тухайн үед сургуулийн зүгээс “Дунд сургууль төгсөнө гэдэг чиний хувьд хангалттай. Ахлах сургуульд дэвшин суралцах шаардлагүй” гэж хэлсэн байна. Тиймээс үргэлжлүүлэн сурч чадаагүй ажээ. Уянгаа өнөөг хүртэл олон албан байгууллагат очиж DET сургалт хийсэн. Цаашид сургуулиудад очиж сургалт хийх зорилготой. Хүүхдүүдэд суралцах боломжийг олгохын тулд тэдэнд ямар саад тулгарч байгааг холбогдох хүмүүстэй ярилцаж, шийдвэрлэх арга замыг бодож олохыг хүсдэг гэж байв. Түүний гэр бүлийнхэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдэд хандаж “Хүүхдүүдэд энгийн хүмүүстэй адил хөгжих боломжийг нь олгох хэрэгтэй. Тийм учраас бага балчир үеэс нь л нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах хэрэгтэй.” гэсэн мессежийг хүргэхийг хүсдэг гэж байлаа.





Энхмаа: Гадаад төрхөөрөө өөрийгөө илэрхийлэхийг хүсдэг.

Энхмаа саажилттай бөгөөд сургагч багш нарын дотроос хамгийн ганган нь. Хувцас сонголт, нүүр будаг, үс засалт гээд зөрж өнгөрсөн хүмүүс эргэж хармаар дэгжин. Энэ бүхэнд эгчийнх нь нөлөө их байсан ба ямар ч үед биеэ сайхан авч явдаг эгчээсээ үлгэр дууриал авдаг гэж байлаа. Тэрээр өөрийн бэрхшээлийнхээ онцлогоос шалтгаалж санамсаргүй байдлаар хувцас, үсэндээ хүрч муухай болгох тохиолдол байдаг учраас гадаад төрхөндөө нэг бүрчлэн анхаарал хандуулдаг байна. Жирийн үед асуудалгүй боловч алхах үедээ бага зэрэг тэнцвэргүй явдаг. Түүнд тулгардаг хөгжлийн бэрхшээл бол эргэн тойрны хүмүүсийн хандлага юм. Тухайлбал “Би ямар ч муу зүйл хийгээгүй байхад дэлгүүр хэсэх үед хүмүүс намайг гайхсан нүдээр хардаг нь хэцүү санагддаг” гэж байв. Энхмаа DET Сургагч багш бэлтгэх сургалтанд хамрагдсанаар хөгжлийн бэрхшээл гэж юу болох, хаана байдаг талаар ойлголттой болжээ. Ирээдүйд энэ салбарт ажиллах юмсан гэсэн хүсэлтэй байсан боловч ямар арга барилаар хэрхэн ажиллахаа мэддэггүй байж. Цаашид сургуулиудад DET сургалт хийж хүүхдүүд, багш нар т хөгжлийн бэрхшээлийн талаар зөв ойлголт өгөхийг хүсдэг. Түүнчлэн гадаад хэл суралцах сонирхолтой бөгөөд англи, хятад хэл сурахын хажуугаар хөгжлийн бэрхшээлийн нөлөөллийн ажил хийхийг зорьж байна.

Супер туслагч Пүрэвжаргал

Та бүхэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслах ажлыг хэцүү ажил гэж боддог уу?

Пүрэвжаргал өөрийн хань Поогий (12/17-ны фэйсбүүк нийтлэлээс уншина уу)-той учирснаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслах ажил хийж эхэлжээ. “Заримдаа ядрах үе байдаг боловч үйлчилгээ үзүүлж буй хүмүүстэйгээ ярилцах нь их хөгжилтэй. Өдөр бүр инээд хөөр, баяр баясалтай учирдаг” хэмээн тэрээр өгүүлж байлаа. Түүний хувьд туслахын ажлаа хийх явцад хамгийн их тулгамддаг асуудал бол шат юм. Тиймээс налуу зам, цахилгаан шат байхгүй барилга байгууламж руу орох, гарах үедээ эргэн тойрны хэн нэгэн хүнээс тусалцаа гуйж, үйлчлүүлэгчээ өргөдөг байна. Гэхдээ хүмүүс түүнд “Туслах ажилтны ачаар гэрээсээ гадагш гардаг болсон. Ийм үйлчилгээ байхгүй байсан бол өдийд гэртээ л байж байх байсан” гэж хэлэх нь хамгийн сайхан санагддаг бөгөөд тийм үед л хийж буй ажлаараа бахархах сэтгэгдэл төрдөг хэмээн инээмсэглэн ярьж байлаа. Түүнчлэн тэрээр Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)-ын дэмжигч туслахаар ажилладаг. Туслах ажилтны хувиар DET сургалтанд маш олон удаа оролцсон учраас сургалтын агуулгыг хэн хүнээс илүү сайн мэддэг бөгөөд дасгал ажлын үеэр шаардлагатай бэлтгэл ажлуудыг хэнээр ч хэлүүлэлтгүй гүйцэтгэдэг. Одоо бол Жагаа DET сургалтын хамгийн чухал байр суурийг эзэлдэг хүн. Тийм ч учраас сургагч багш нар түүнийг “Супер туслагч” гэж нэрлэдэг. “DET Монголд хамгийн хэрэгцээтэй сургалт. Сургалтанд оролцож буй хүмүүсийн ойлголт, хандлага нүдний өмнө өөрчлөгддөг учраас маш их урам зориг авдаг!” Монгол дахь хөгжлийн бэрхшээлийн асуудал нь зөвхөн шат, доголыг арилгах асуудал биш юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хандах ойлголт, хандлагыг өөрчлөх нь маш чухал хэмээн боддог гэж байлаа. Өнөөдөр ч гэсэн Жагаа хэн нэгний төлөө сэтгэл өөдрөг ажиллаж яваа...

